



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 6/06

Ховд

Лхагважавын Батгэрэлийг ажилд томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 27.1.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 221 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Л.Батгэрэлийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтнээр 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Л.Батгэрэлийн ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил үүргийг хариуцуулан удирдлагаар ханган, ажил хүлээлцүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга / С.Гантөмөр /-д үүрэг болгосугай.

3. Л.Батгэрэлийг Монгол улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-5-ын 1 дэх шатлал 594803 төгрөг /таван зуун ерөн дөрвөн мянга найман зуун гурав/-өөр цалинжуулахыг Санхүү, аж ахуйн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

2019 ТГ 6/06 Ч
02 0071